



**ОЛОН УЛСЫН УЛААНБААТАРЫН  
ИХ СУРГУУЛЬ**

**РЕКТОРЫН ТУШААЛ**

2026 он 05 сар 19 өдөр

Дугаар А/92

Улаанбаатар хот

**2026-2027 оны хичээлийн жилд бакалаврын хөтөлбөрт оюутан  
элсүүлэх журмыг батлах тухай**

БШУ-ны сайдын 2024 оны 3 сарын 20-ны өдрийн А/143 тоот "Журам шинэчлэн батлах тухай", 2026 оны 2 сарын 06-ны өдрийн А/34 тоот тушаал болон 2026 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн Захиргааны зөвлөлийн шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1. 2026-2027 оны хичээлийн жилд бакалаврын хөтөлбөрт "Оюутан элсүүлэх журам"-ыг нэгдүгээр хавсралтаар, Дизайн, Сувилахуй, Багш, гадаад хэлний боловсрол /Англи хэл/, Багш, гадаад хэлний боловсрол /Солонгос хэл/, Аялал жуулчлал, Мал зүйн хөтөлбөрийн элсэгчдээс авах ур чадварын шалгалтын удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Элсэлтийн үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй бөгөөд аливаа асуудлыг шуурхай шийдвэрлэж, элсэлтийн журмыг баримталж ажиллахыг Элсэлт, зар сурталчилгааны алба (Ким Жэ Сон), Сургалтын алба (Б.Туяа), Оюутны алба (Ким Жэ Сон) болон элсэлтийн комисст даалгасугай.

РЕКТОР



КАН ЮУ ЁЛЬ



## 2026-2027 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨРТ ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Олон улсын Улаанбаатарын их сургууль (ОУУБИС) нь 2026-2027 оны хичээлийн жилийн элсэлтэд БШУ-ны сайдын 2024 оны 3 сарын 20-ны өдрийн А/143 тоот “Журам шинэчлэн батлах тухай” тушаал, Боловсролын сайдын 2026 оны 2 сарын 06-ны өдрийн А/34 тоот тушаал, “Боловсролын ерөнхий хууль”, Дээд боловсролын тухай” хуулийг баримтална.

1.2. 2026-2027 оны хичээлийн жилийн элсэлтийн бүртгэлийн үйл ажиллагааг <http://elselt.iuu.edu.mn/> elselt хаягаар онлайнаар болон биечлэн зохион байгуулна.

1.3. Сургуулийн элсэлтийн комисс нь элсэгчдийг бүртгэх, оноогоор жагсаах, элсүүлэх хяналтын тоог баримтлан хөтөлбөр сонгуулах, элсэгчдийн өргөдөл хүсэлтийг барагдуулах зэрэг үйл ажиллагааг ил тод, олон нийтийн хяналтын хүрээнд явуулна.

### ХОЁР. ЭЛСЭГЧДЭД ТАВИХ НИЙТЛЭГ ШААРДЛАГА

2.1. ОУУБИС-д элсэгч нь бүрэн дунд буюу түүнээс дээш боловсролтой байна.

2.2. Элсэгч нь Боловсролын үнэлгээний төвөөс цахимаар олгосон батламжтай байна.

2.3. ОУУБИС-д ямар нэг мэргэжлээр элсэхийг хүсэгч нь Элсэлтийн шалгалт (ЭШ) нэгдүгээр хичээл болон хоёрдугаар хичээлээр яамнаас тогтоосон босго онооноос дээш оноо авсан байна. (хүснэгт 1).

2.4. Бакалаврын хөтөлбөрт суралцах хүсэлтэй иргэнийг дараах шалгуурын аль нэгийг хангасан тохиолдолд элсэлтийн шалгалтын оноо шаардахгүйгээр элсүүлэн суралцуулна. Үүнд:

2.4.1. Дэд бакалавр, бакалаврын боловсролтой иргэн;

2.4.2. Политехник коллеж, шаталсан сургалттай дээд боловсролын сургалтын байгууллагын төгсөгч тухайн мэргэжлийн чиглэлээр дэд бакалавр, бакалаврын хөтөлбөрт элсэхэд ЭШ-ын оноо шаардахгүй;

2.4.3. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хүлээн зөвшөөрсөн олон улсын болон улсын төрөлжсөн олимпиадын эхний 5 байрт шалгарсан иргэн тухайн чиглэлийн хөтөлбөрт;

2.4.4. Гадаад болон дотоодын ерөнхий боловсролын сургуульд суралцаж бүрэн дунд боловсрол эзэмшин, олон улсад нийтлэг хүлээн зөвшөөрөгддөг шалгалтын дүн, оноог Боловсролын үнэлгээний төвөөр дүйцүүлэн тооцуулж батламж авсан иргэн;

2.4.5. Элсэн суралцах мэргэжлийн чиглэл/ хөтөлбөр/-ээр 3-аас доошгүй жил ажилласан, 30-аас дээш насны иргэн;

2.5. Олон улсын хөтөлбөртэй Монгол улсын ерөнхий боловсролын сургууль төгсөгч нь олон улсын үнэлгээгээ элсэлтийн шалгалтын үнэлгээнд дүйцүүлэх эсвэл элсэлтийн шалгалтад хамрагдаж авсан онооныхоо аль өндөр оноогоор элсэн орж болно.

2.6. Гадаадын иргэд элсэн суралцах хүсэлт гаргавал монгол хэлний мэдлэг, чадварын шалгалт эсвэл англи хэлний олон улсын шалгалтын оноог харгалзан элсүүлэн суралцуулна.

2.7. “Монгол хэлний тухай” хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу гадаадын иргэнээс авах монгол хэлний түвшин тогтоох шалгалтын агуулга нь эрх бүхий байгууллагаас боловсруулсан агуулгын хүрээнд байна.

2.8. Бакалаврт элсэн суралцахыг хүссэн гадаад иргэнээс монгол хэлний мэдлэг, чадварын шалгалтыг сургалтын алба зохион байгуулан авна.

2.9. Гадаад иргэн нь монгол хэлний мэдлэггүй бол ОУУБИС-ийн Монгол хэлний сургалтын төвд 1 жил суралцана.

2.10. Гадаад иргэн нь монгол хэлний мэдлэг, чадварын шалгалтад дундаас дээш түвшний үнэлгээ авсан тохиолдолд бакалаврын сургалтад элсэн суралцах боломжтой болно.

2.11. Гадаад иргэн нь монгол хэлний ярианы болон бичгийн шалгалтад дундаас доош түвшний үнэлгээ авбал ОУУБИС-ийн Монгол хэлний сургалтын төвд 6 сараас 1 жилийн хугацаатай төлбөртэй сургалтад дахин хамрагдана.

2.12. Суралцах эрх авсан гадаад иргэнтэй ОУУБИС-д суралцах, суралцуулах гэрээ байгуулж, Ректорын тушаалаар баталгаажуулна.

2.13. Дизайн, Сувилахуй, Багш гадаад хэлний боловсрол /солонгос хэл/, Багш, гадаад хэлний боловсрол /англи хэл/, Аялал жуулчлал, Мал зүй хөтөлбөрөөр элсэгч нь “Ур чадварын шалгалт” өгнө.

2.14. “Ур чадварын шалгалт”-ыг элсэн суралцах мэргэжлийн онцлогтой уялдуулан асуумж, эсээ, ярилцлага, натюрморт зурах, сэдэвт зохиомж зурах хэлбэрээр авч, шалгуулагчийн ур чадварыг үнэлнэ.

2.15. Ур чадварын шалгалтын гүйцэтгэлийн хувь буюу анхны онооноос хэмжээст оноо (хэмжээст оноо нь 200-аас 800-гийн хооронд байна)-г хөтөлбөр бүрээр БШУ-ны сайдын 2024 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн А/143 дугаар тушаалын 1-р хавсралт “Оюутан элсүүлэх журам”-ын 3.2.9 -д заасан аргачлалаар тооцно. Анхны оноог А, хэмжээст оноог Х гэж тэмдэглээд дараах байдлаар оноо (Х)-г тооцоолно. Үүнд:

- Хэрэв шалгуулагчийн анхны оноо 0-ээс 59-ийн хооронд бол  $X=200+A*4.66$
- Хэрэв шалгуулагчийн анхны оноо 60-аас 100-ын хооронд бол  $X=480+(A-60)*8$  гэсэн томъёогоор олно.

Анхны онооны интервалд харгалзах хэмжээст оноог хүснэгтээр харуулав.

	Анхны оноо	Хэмжээс оноо
1	0-59	200-479
2	60-64.9	480-519
3	65-69.9	520-559
4	70-74.9	560-599
5	75-79.9	600-639
6	80-84.9	640-679
7	85-89.9	680-719
8	90-94.9	720-759
9	95-100	760-800

2.16. Ур чадварын шалгалтад 60 (хэмжээст оноогоор 490) болон түүнээс дээш оноо авсан тохиолдолд тухайн ур чадварын шалгалтад тэнцсэн гэж үзнэ.

2.17. Элсэгчийн ур чадварын шалгалтын оноо нь ОУУБИС-ийн Дизайн, Сувилахуй, Багш, гадаад хэлний боловсрол /солонгос хэл, англи хэл/, Аялал жуулчлал, Мал зүйн хөтөлбөрийн хувьд л хүчинтэй байна.

2.18. Энэхүү журмын 2.4.5.-д заасан бүртгүүлэгчийн ажлын газрын тодорхойлолт, нийгмийн даатгал төлсөн лавлагаа, өргөдөл болон эсээ /суралцах бэлтгэл хангасан байдал, авьяас чадвар, туршлага, хувийн зан чанар, хэрхэн суралцахаа илэрхийлэх гэх мэт агуулгыг тусгасан байна/ зэргийг үндэслэн элсүүлнэ.

2.19. Өвлийн буюу 2 дахь удаагийн элсэлтийг сургуулийн удирдах зөвлөлөөс баталсан хөтөлбөр бүрээр оюутан элсүүлэх хяналтын тоог гүйцээх байдлаар зохион байгуулна. Тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр өвлийн элсэлт зохион байгуулах бол хаврын элсэлтийн тоотой нэгтгэсэн байдлаар баталсан аргачлалын дагуу тооцож нэмэлт хяналтын тоог тогтооно.

2.20. Элсэлтийн комиссын гишүүд оюутан элсүүлэхтэй холбоотой аливаа маргаан, бүртгүүлэгч болон тэдний хууль ёсны төлөөлөгчийн гаргасан санал, гомдлыг тухай бүрд нь шуурхай шийдвэрлэх, элсэлтийн явцад хяналт тавих, элсэлттэй холбоотой бүхий л үйл ажиллагааг зохицуулна.

2.21. БШУ-ны сайдын 2024 оны 3-р сарын 20-ны өдөр батлагдсан "Оюутан элсүүлэх журам"-ын хоёрдугаар хавсралтаар батлагдсан элсэлтийн хяналтын тоог тогтоох аргачлалаар тооцсон хяналтын тоонд багтаж оюутан элсүүлнэ.

2.22.Элсэгч нь дараах тохиолдолд төлбөрийн хөнгөлөлтөд хамрагдана.

Тэтгэлийн төрөл	Ангилал		Тэтгэлэг	Хугацаа
Дүнгийн тэтгэлэг	ЭШ-ийн оноо /хичээл 1, хичээл 2 дундаж оноогоор тооцно/	ЭШ 510~ 599	30%	1 жил (1-р улирлын голч дүн 3.3 бол дараа улиралд үргэлжлүүлэн авна.)
		ЭШ 600~ 649	50%	1 жил(голч 3.3)
		ЭШ 650 ~699	70%	1 жил(голч 3.3)
		ЭШ 700-аас дээш	100%	1 жил(голч 3.3)
Харьяа бүрэн дунд сургууль	Төгсөгч	ЭШ 500-аас дээш	50%	1 жил(голч 3.3)
Ах эгч дүү	Төрсөн ах эгч дүүс		30%	1 жил(голч 3.3)
Төгсөгчийн хүүхэд	ОУУБИС-ийн төгсөгчийн хүүхэд		30%	1 жил(голч 3.3)

Нэмэлт тайлбар:

1.Хөнгөлөлттэй элсэн суралцагчийн тэтгэлэг нь тухайн эхний улиралд хамаарахаас гадна дараа улирлын хөнгөлөлт нь эхний улирлын дүнгийн голчоос шалтгаална. Үүнд: Эхний улирлын голч дүн 3.3` байвал үргэлжлүүлэн тэтгэлэгт хамрагдана.

2.Хичээлийн жилийн 3-р улирлаас ОУУБИС-ийн “Тэтгэлэг олгох журам”-ын дагуу тэтгэлэгт хамрагдаж болно.

3.Төрийн албан хаагчид 10% хөнгөлөлттэй.

4.Суралцагчид тэтгэлгийг давхардуулан олгохгүй.

## ГУРАВ. ЭЛСҮҮЛЭХ ОЮУТНЫГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ

3.1.Элсэлтийн шалгалт өгч, их дээд сургуульд элсэх болзлыг хангасан иргэн <http://elselt.iuu.edu.mn/> хаягаар онлайн болон сургууль дээр ирж биеэр бүртгүүлнэ.

3.2.Хаврын элсэлтийг үнэлгээний төвөөс олгосон 2024, 2025, 2026 элсэлтийн шалгалтын батламжийн оноогоор, өвлийн элсэлтийг үнэлгээний төвөөс олгосон 2025, 2026 оны элсэлтийн шалгалтын батламжийн оноогоор бүртгүүлэн элсэж болно. Шалгалтыг дахин өгсөн хүний хувьд өндөр оноотой зөвхөн нэг батламжаар бүртгэнэ.

3.3.Босго онооны болзол хангасан бүртгүүлэгчдэд “ОУУБИС-д суралцах эрхийн бичиг”-ийг олгоно.

3.4.“ОУУБИС-д суралцах эрхийн бичиг” авсан элсэгчдийн материалыг элсэлтийн комисс хүлээн авах бөгөөд дараах материалыг бүрдүүлсэн байна. Үүнд:

- Иргэний үнэмлэхийн хуулбар
- Бүрэн дунд боловсролын гэрчилгээ, түүнтэй адилтгах баримт бичиг
- Хувийн хэрэг

- Элсэлтийн шалгалтын батламж
- 3-4 хэмжээний цээж зураг 2 хувь
- Бүртгэлийн хураамж төлсөн баримт

*Хугацаа, байр:* Хаврын элсэлт 2026 оны 6 дугаар сарын 29, өвлийн элсэлт 2027 оны 1 дүгээр сарын 4-ны өдрөөс тус тус сургуулийн хичээлийн 1 дүгээр байр

*Хаяг:* Баянзүрх дүүрэг, 25 дугаар хороо, 13 дугаар хороолол, Намянжүгийн гудамж, Улаанбаатар-210644, Ш/х-658

*Холбоо барих утас:* 462026,462027, 89472026

*Веб хаяг:* [www.iuu.edu.mn](http://www.iuu.edu.mn)

## **ДӨРӨВ. ШИНЭ ОЮУТНЫГ БҮРТГЭХ, СУРАЛЦУУЛАХ ГЭРЭЭ БАЙГУУЛАХ**

4.1.Элсэлтийн шалгалт өгч, их дээд сургуульд элсэх болзлыг хангаж “ОУУБИС-д суралцах эрхийн бичиг” авсан элсэгч нь 2026 оны 8 дугаар сарын 30-ны дотор (өвлийн элсэлт бол 2027 оны 1 дүгээр сарын 25-ны дотор) өөрийн биеэр ирж суралцах гэрээ байгуулна. Гэрээ байгуулахад дараах 6 материалыг бүрдүүлнэ. Үүнд:

- Иргэний үнэмлэхийн хуулбар
- Бүрэн дунд боловсролын гэрчилгээ, түүнтэй адилтгах баримт бичиг
- Хувийн хэрэг
- Элсэлтийн шалгалтын батламж /эх хувь/
- 3-4 хэмжээний цээж зураг 2 хувь
- Сургалтын төлбөр төлсөн баримт

***Бүртгэх хугацаа:*** Хаврын элсэлт 2026 оны 6 дугаар сарын 29-ний өдрөөс 8 дугаар сарын 29-ны өдөр, өвлийн элсэлт 2027 оны 1 дүгээр сарын 4-ны өдрөөс 1 дүгээр сарын 23-ны өдөр хүртэл ОУУБИС-ийн хичээлийн 1 байр (SUNDAY PLAZA худалдааны төвийн эсрэг талд байрлах бага, бүрэн дунд болон их сургуулийн цогцолбор байр)

ОУУБИС-ийн бакалаврын өдрийн ангид 2026-2027 оны хичээлийн жилд оюутан элсүүлэх хөтөлбөр,  
элсэлтийн шалгалтын өгөх хичээл

№	Индекс	Хөтөлбөрүүд	Элсэлтийн шалгалт, босго оноо			
			ЭШ-1	Босго оноо	ЭШ-2	Босго оноо
<b>СУВИЛАХУЙН СУРГУУЛЬ</b>						
1	091301	Сувилахуй	Хими, Биологи	430	Ур чадвар	450
<b>ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛЬ</b>						
1	042101	Эрх зүй	Нийгэм судлал	490	Математик, Англи хэл	490
<b>ХҮМҮҮНЛЭГ, НИЙГМИЙН УХААНЫ СУРГУУЛЬ</b>						
1	023101	Гадаад хэлний орчуулга (Англи хэл, Солонгос хэл)	Англи хэл, Орос хэл, Математик	490	Нийгэм судлал, Монгол хэл, Түүх	490
2	022203	Олон улс орон судлал	Англи хэл, Орос хэл	490	Нийгэм судлал, түүх	490
3	011435	Багш, гадаад хэлний боловсрол (Англи хэл, Солонгос хэл)	Англи хэл, Орос хэл, Монгол хэл	490	Ур чадвар	490
4	023202	Хэл шинжлэл	Монгол хэл, Нийгэм судлал	490	Түүх, Англи хэл	490
5	031402	Социологи	Нийгэм судлал, Түүх	490	Математик, Англи хэл	490
6	031301	Сэтгэл судлал	Нийгэм судлал, Математик	490	Монгол хэл, Англи хэл	490
7	031202	Олон улсын харилцаа	Англи хэл, Орос хэл	490	Нийгэм судлал, Түүх	490
8	092301	Нийгмийн ажил	Нийгэм судлал, Англи хэл	490	Монгол хэл, Математик	490
<b>ИНЖЕНЕР, ДИЗАЙН, ТЕХНОЛОГИЙН СУРГУУЛЬ</b>						
1	021105	График дизайн	Математик, Англи хэл	450	Ур чадвар	490
2	021203	Үйлдвэрлэлийн дизайн	Математик, Англи хэл	450	Ур чадвар	490
3	021204	Интерьер дизайн	Математик, Англи хэл	450	Ур чадвар	490
4	021202	Хувцасны дизайн	Математик, Англи хэл	450	Ур чадвар	490
5	061302	Программ хангамж	Математик, Физик	490	Нийгэм судлал, Англи хэл	450
6	061303	Мэдээллийн систем	Математик, Физик	490	Нийгэм судлал, Англи хэл	450
7	071401	Электроникийн инженерчлэл	Математик, Физик	490	Нийгэм судлал, Англи хэл	450
8	081102	Мал зүй	Хими, Биологи Математик	490	Ур чадвар	490
9	082101	Ойн аж ахуй	Хими, Биологи Физик	440	Математик, Нийгэм судлал	490
<b>ЭДИЙН ЗАСАГ, БИЗНЕСИЙН СУРГУУЛЬ</b>						
1	041301	Бизнесийн удирдлага	Математик	490	Англи хэл, Нийгэм судлал	490
2	041201	Санхүү, Банк	Математик	490	Англи хэл, Нийгэм судлал	490
3	041303	Менежмент	Математик	490	Англи хэл, Нийгэм судлал	490
4	041401	Маркетинг	Математик	490	Нийгэм судлал, Англи хэл	490
5	041101	Нягтлан бодох бүртгэл	Математик	490	Англи хэл, Нийгэм судлал	490

6	101501	Аялал жуулчлал	Газарзүй, Математик, Англи хэл	490	Ур чадвар	490
7	031101	Эдийн засаг	Математик	490	Нийгэм судлал, Англи хэл	490



## ЭЛСЭГЧДЭЭС “ХАР ЗУРАГ”-ИЙН УР ЧАДВАРЫН ШАЛГАЛТ АВАХ УДИРДАМЖ

ОУУБИС, Инженер, Дизайны Технологийн сургуулийн Дизайны тэнхимийн Хувцасны дизайн, График дизайн, Үйлдвэрлэлийн дизайн, Интерьер дизайн мэргэжлээр бакалаврын хөтөлбөрт элсэгчдийн ур чадварын (хар зураг) шалгалтыг БШУ-ны Сайдын А/143 дугаар тушаалын 1-р хавсралт, “Оюутан элсүүлэх журам”-ын 2 болон 3.2 дахь заалтыг тус тус баримтлан зохион байгуулна.

Ур чадварын шалгалтыг элсэн суралцах дизайны хөтөлбөрийн онцлогтой уялдуулан “Натюрморт зурах” хэлбэрээр авч, шалгуулагчийн ур чадварыг үнэлнэ.

### Нэг: Шалгуулагчийн бэлдэж ирэх зүйлс

- Планшет (хэмжээ А3)
- Ватом цаас 1ш (хэмжээ А3)
- Скоч
- Цаасны хутга
- Хатуу, зөөлөн балтай харандаа
- Зөөлөн баллуур

### Хоёр: Гүйцэтгэх даалгаврын агуулга, хэлбэр

2.1 Хар зургийн шалгалтыг натюрморт буюу геометр биетийг ватом цаасан дээр зуруулж авна.

2.2 Натюрмортыг цайвар өнгөтэй даавуун дээр гипсэн материалаар хийгдсэн шоо дөрвөлжин, призм, бөмбөрцөг, конус, пирамид, цилиндр гэх мэт биетүүдээс сонгон 3-4 биет оролцуулан зохиомжлон тавина.

2.3 Натюрмортыг харааны түвшний доор, тавцан, аравч ашиглаж, цайвар өнгийн даавуун дээр гэрэл, сүүдэр тодорхой байхаар анги, кабинетын гэрэлтүүлгийн байдлыг харгалзан зохиомжлон тавина. (Зохиомол гэрэл ашиглаж болно)

### Гурав: Шалгалтын зохион байгуулалт, байршил, хугацаа

3.1 Шалгуулагчийн бүрийн ур чадварын шалгалтыг хавар, намар, өвлийн элсэлтийн хугацаанд ОУУБИС. А байр. Дизайны тэнхимийн анги, танхимд зохион байгуулна.

3.2 Шалгуулагчийн ур чадварын шалгалтын үргэлжлэх хугацаа 120 минутаас ихгүй байна.

3.3 Шалгуулагчийн бүртгэлийн хугацаанаас хамаарч ур чадварын шалгалтыг “Ур чадварын шалгалтын комисс”-ын шийдвэрийг үндэслэн тухай бүрт нь зохион байгуулж болно.

#### Дөрөв: Үнэлгээний шалгуур, үзүүлэлт

4.1 Шалгуулагч бүрийн "Хар зураг"-ийн ур чадварын анхны оноо буюу гүйцэтгэлийн хувийг 100 оноогоор тооцоолох ба анхны оноо дараах агуулгын онооны нийлбэрээс бүрдэнэ. Үүнд:

- **Зохиомж** **35 оноо**
  - **Байгуулалт** **35 оноо**
    - Алслалт /шугаман алслалт, тойргийн алслалт/ (15 оноо)
    - Харьцаа (20 оноо)
  - **Гэрэл сүүдэр** **30 оноо**
    - Зурааслалт (10 оноо)
    - Орон зай (10 оноо)
    - Хэлбэр (форм) (10 оноо)
- Нийт 100 оноо**

4.2 Ур чадварын шалгалтын гүйцэтгэлийн хувь буюу анхны онооноос хэмжээст оноо (хэмжээст оноо нь 200-аас 800-гийн хооронд байна)-г хөтөлбөр бүрээр БШУ-ны Сайдын А/143 дугаар тушаалын 1-р хавсралт, "Оюутан элсүүлэх журам"-ын 3.2.9 -д заасан аргачлалаар тооцно.

- Аргачлал: Анхны оноог А, хэмжээст оноог Х гэж тэмдэглээд дараах байдлаар оноо (Х)-г тооцоолно. Үүнд:
  - Хэрэв шалгуулагчийн анхны оноо 0-ээс 59-ийн хооронд бол  $X=200+A*4.66$
  - Хэрэв шалгуулагчийн анхны оноо 60-аас 100-ын хооронд бол  $X=480+(A-60)*8$  гэсэн томъёогоор олно.

Анхны онооны интервалд харгалзах хэмжээст оноог хүснэгтээр харуулав.

	Анхны оноо (А)	Хэмжээс оноо (Х)
1	0-59	200-479
2	60-64.9	480-519
3	65-69.9	520-559
4	70-74.9	560-599
5	75-79.9	600-639
6	80-84.9	640-679
7	85-89.9	680-719
8	90-94.9	720-759
9	95-100	760-800

4.3 Ур чадварын шалгалтад 60 (хэмжээст оноогоор 490) болон түүнээс дээш оноо авсан тохиолдолд тухайн ур чадварын шалгалтад тэнцсэн гэж үзнэ.

4.4 Шалгуулагчийн ур чадварын шалгалтын оноо ОУУБИС-ийн Дизайны хөтөлбөрийн хувьд хүчинтэй байна.

## **СУВИЛАХУЙН ХӨТӨЛБӨРҮҮДЭЭР ЭЛСЭГЧДЭЭС УР ЧАДВАРЫН ШАЛГАЛТ АВАХ УДИРДАМЖ**

Олон Улсын Улаанбаатарын их сургуульд Сувилахуйн мэргэжлээр элсэгчид ур чадварын (тест, эссэ) шалгалт өгч орно.

### **Нэг. Шалгалтын зохион байгуулалт, байршил, хугацаа:**

- Ур чадварын шалгалтын эхний хэсгийг элсэлтийн шалгалтын дараа жил бүрийн 7 дугаар сарын эхний хагаст багтаан авна.
- Нэмэлт элсэлтээр элсэгчдийн ур чадварын шалгалтыг жил бүрийн 9 дүгээр сарын эхний 14 хоногт багтаан тэнхимдээ авна.
- Хичээлийн II улирлын шилжилт хөдөлгөөнтэй холбоотой шилжиж ирж байгаа оюутнуудаас жил бүрийн хоёрдугаар сарын 3 дахь долоо хоногт багтаан авна.

### **Хоёр. Шалгалтыг дараах хэлбэрээр зохион байгуулна.**

1. Ур чадварын шалгалтын хугацаа: 120 минут
2. Ур чадварын шалгалтын хэлбэр: цахим эсвэл танхим

### **Гурав. Ур чадварын шалгалтыг дараах шалгуураар 100 оноогоор үнэлнэ.**

Элсэгчийн авсан ур чадварын шалгалтын оноог шалгалтын оноонд хөрвүүлж үнэлгээг гаргана (БШУ- ны сайдын 2024 оны 03 сарын 20- ны өдрийн тоот тушаалын 3.2.8, 3.2.9- д заасны дагуу)

1. **Тест (50 оноо)**
  - Ерөнхий боловсролын сургуулийн эрүүл мэндийн боловсрол хичээлийн агуулгаас асуулт оруулна.
2. **Эсээ (50оноо)**
  - 300- аас доошгүй үгтэй
  - Эсээ бичлэгийн асуултад хариулсан байх/ сувилахуйн талаар хэр мэдлэг, яагаад сувилагч болохыг хүссэн, өөрийн ирээдүйн ажил мэргэжлээ хэрхэн төлөвлөж буй талаар/

### **Дөрөв. Ур чадварын шалгалтад оролцогчийн бэлтгэж ирэх зүйлс:**

Бүрэн дунд боловсролын гэрчилгээ, иргэний үнэмлэх, ЭШ-ын батламж, 1 % цээж зураг

**Тав.** Ур чадварын шалгалтад 450 болон түүнээс дээш оноо авсан тохиолдолд тухайн ур чадварын шалгалтад тэнцсэн гэж үзнэ. Ур чадварын шалгалтын оноо нь зөвхөн тус сургууль тэнхимд хамаарна.

**БАГШ, ГАДААД ХЭЛНИЙ БОЛОВСРОЛ /АНГЛИ ХЭЛ/ ХӨТӨЛБӨРӨӨР  
ЭЛСЭГЧДЭЭС УР ЧАДВАРЫН ШАЛГАЛТ АВАХ УДИРДАМЖ**

ОУУБИС, бгаш гадаад хэлний боловсрол (Англи хэл) хөтөлбөрөөр элсэгчдийн ур чадварын шалгалтыг БШУ-ын сайдын 2024 оны 3 дугаар сарын 20- ны өдрийн А/ 143 дугаар тушаалын 1- р хавсралт “ Оюутан элсүүлэх журам ” -ын 2 болон 3.2 дахь заалтыг тус тус баримтлан зохион байгуулна. Тус хөтөлбөрөөр элсэгчдийн ур чадварын шалгалтыг “эсээ бичих ” даалгавар гүйцэтгүүлж авна.

**Нэг. Ур чадварын шалгалтад оролцогчийн бэлтгэж ирэх зүйлс:**

- Бүрэн дунд боловсролын гэрчилгээ, иргэний үнэмлэх, ЭШ-ийн батламж, 1 хувь цээж зураг

**Хоёр. Шалгалтын зохион байгуулалт, байршил, хугацаа, шалгалтын хэлбэр**

- Ур чадварын шалгалтыг комисс элсэлтийн бүртгэлийн хугацаанд бүртгэл авч байгаа цаг дээр бэлэн ажиллах ба элсэн суралцах хүсэлт гаргагчаас шууд газар дээр нь шалгалт авч дүнг мэдэгдэнэ. Нэмэлт элсэлтээр элсэгчдийн ур чадварын шалгалтыг жил бүрийн 9 дүгээр сарын эхний 14 хоногт багтаан тэнхимдээ авна. Хичээлийн I улирлын шилжилт хөдөлгөөнтэй холбоотой шилжиж ирж байгаа оюутнуудаас жил бүрийн хоёрдугаар сарын 3 дахь долоо хоногт багтаан авна. Ур чадварын шалгалтын хугацаа нь 60 минут байх бөгөөд шалгалт авах хэлбэр нь танхимаар зохион байгуулагдана.

**Гурав. Гүйцэтгэх даалгаврын агуулгын бүтэц**

Тодорхой өгөгдсөн сэдвийн хүрээнд 350-500 үгтэй эсээ бичих бөгөөд эсээг 100 оноогоор дүгнэнэ. Онооны бүтэц нь:

Үнэлгээний чиглэл	Агуулга	Онооны хувь
Бүтэц	Оршил, их бие, дүгнэлт логик уялдаа холбоо	25 %
Найруулга зүй	Үгийн сонголт, хэл найруулга зүйн ур чадвар	25 %
Цогцолбор хоорондын уялдаа холбоо	Сэдэв зорилго, агуулга, дүгнэлтийн уялдаа холбоо	25 %
Шинэлэг санаа	Дэвшүүлсэн шинэлэг санаа, бүтээлч байдал	25 %

**Дөрөв. Үнэлгээний аргачлал**

4.1 Ур чадварын шалгалтын гүйцэтгэлийн хувийг хөтөлбөр бүрээр 100 онооноос тооцоолж гаргана. Улмаар энэхүү анхны онооноос хэмжээст оноо (хэмжээст оноо нь 200-800 ийн хооронд байна) г БШУ-ын сайдын А/ 143 дугаар тушаалын 1- р хавсралт “Оюутан элсүүлэх журам ”-ын 3.2.9 – д заасан аргачлалаар тооцно.

- Аргачлал: Анхны оноог А, хэмжээст оноог Х гэж тэмдэглээд дараах байдлаар ( Х)- г тооцоолно. Үүнд:
  - Хэрэв шалгуулагчийн анхны оноо 0- ээс 59 -ийн хооронд бол  $X=200+A*4.66$
  - Хэрэв шалгуулагчийн анхны оноо 60-аас 100- ын хооронд бол  $X=480+(A-60)*8$  гэсэн томъёогоор бодно.

4.2 Анхны онооны интервалд харгалзах хэмжээст оноог хүснэгтээр харуулав.

	Анхны оноо	Хэмжээст оноо
1	0-59	200-479
2	60-64.9	480-519
3	65-69.9	520-559
4	70-74.9	560-599
5	75-79.9	600-639
6	80-84.9	640-679
7	85-89.9	680-719
8	90-94.9	720-759
9	95-100	760-800

4.3 Ур чадварын шалгалтад хэмжээст оноогоор 490 болон түүнээс дээш авсан тохиолдолд тэнцсэн гэж үзнэ.

4.4 Шалгуулагчийн ур чадварын шалгалтын оноо ОУУБИС-ийн багш, гадаад хэлний боловсрол (Англи хэл) хөтөлбөрийн хувьд хүчинтэй байна.

**БАГШ, ГАДААД ХЭЛНИЙ БОЛОВСРОЛ /СОЛОНГОС ХЭЛ/  
ХӨТӨЛБӨРӨӨР ЭЛСЭГЧДЭЭС  
УР ЧАДВАРЫН ШАЛГАЛТ АВАХ УДИРДАМЖ**

ОУУБИС, Багш, гадаад хэлний боловсрол (Солонгос хэл) хөтөлбөрөөр элсэгчдийн ур чадварын шалгалтыг БШУ-ны сайдын 2024 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн А/143 дугаар тушаалын 1-р хавсралт “Оюутан элсүүлэх журам”-ын 2 болон 3.2 дахь заалтыг тус тус баримтлан зохион байгуулна. Тус хөтөлбөрөөр элсэгчдийн ур чадварын шалгалтыг “эсээ бичих” даалгавар гүйцэтгүүлж авна.

**Нэг. Ур чадварын шалгалтад оролцогчийн бэлтгэж ирэх зүйлс:**

- Бүрэн дунд боловсролын гэрчилгээ, иргэний үнэмлэх, ЭШ-ийн батламж, 1 хувь цээж зураг

**Хоёр. Шалгалтын зохион байгуулалт, байршил, хугацаа**

- Ур чадварын шалгалтын комисс элсэлтийн бүртгэлийн хугацаанд бүртгэл авч байгаа цэг дээр бэлэн ажиллах ба элсэн суралцах хүсэлт гаргагчаас шууд газар дээр нь шалгалт авч дүнг мэдэгдэнэ.

**Гурав. Гүйцэтгэх даалгаврын агуулгын бүтэц**

- 300-аас доошгүй үгтэй эсээ бичих
- Онооны бүтэц
  - 40% — Хэлний ур чадвар (эсээ бичих чадвар, найруулга, бүтэц гэх мэт)
  - 60% — Сэтгэл зүй, мэргэжлийн хандлага, ирээдүйн зорилго

**Дөрөв. Үнэлгээний шалгуур, үзүүлэлт**

4.1.

Үнэлгээний чиглэл	Агуулга	Онооны хувь
<b>Эсээ бичих чадвар (нийт 40%)</b>		
Бүтэц	Оршил, гол хэсэг, төгсгөл логик уялдаатай эсэх	10%
Эсээ бичлэгийн асуултад хариулсан байх	Агуулгын асуултын дагуу бичсэн байх	10%
Найруулга зүй	Холбох үгсийн зөв хэрэглээ, өгүүлбэр хоорондын логик холбоо зэрэг	10%
Үгийн тоо	Үгийн тоо гүйцсэн эсэх	10%
<b>Сэтгэл зүй, хандлага ба ирээдүйн зорилго (нийт 60%)</b>		
Багш мэргэжлийг сонгосон сэдэл	Яагаад багш болохыг хүссэн тухай	20%
Зан чанар, хандлага	Сурагчидтай харилцах ойлголт, хүмүүжил, хүнлэг байдал	20%
Ирээдүйн зорилго, алсын хараа	Ирээдүйн багшийн хувийн төлөвлөгөө, мэргэжлийн үзэл баримтлал	20%
<b>Нийт</b>		<b>100 оноо</b>

4.2. Ур чадварын шалгалтын гүйцэтгэлийн хувийг хөтөлбөр бүрээр 100 онооноос тооцоолж гаргана. Улмаар энэхүү анхны онооноос хэмжээст оноо (хэмжээст оноо нь 200-800-ийн хооронд байна)-г БШУ-ны сайдын А/143 дугаар тушаалын 1-р хавсралт, "Оюутан элсүүлэх журам"-ын 3.2.9 -д заасан аргачлалаар тооцно.

- Аргачлал: Анхны оноог А, хэмжээст оноог Х гэж тэмдэглээд дараах байдлаар оноо (Х)-г тооцоолно. Үүнд:
  - Хэрэв шалгуулагчийн анхны оноо 0-ээс 59-ийн хооронд бол  $X=200+A*4.66$
  - Хэрэв шалгуулагчийн анхны оноо 60-аас 100-ын хооронд бол  $X=480+(A-60)*8$  гэсэн томъёогоор олно.

Анхны онооны интервалд харгалзах хэмжээст оноог хүснэгтээр харуулав.

	Анхны оноо	Хэмжээс оноо
1	0-59	200-479
2	60-64.9	480-519
3	65-69.9	520-559
4	70-74.9	560-599
5	75-79.9	600-639
6	80-84.9	640-679
7	85-89.9	680-719
8	90-94.9	720-759
9	95-100	760-800

4.3. Ур чадварын шалгалтад хэмжээст оноогоор 490 болон түүнээс дээш оноо авсан тохиолдолд тэнцсэн гэж үзнэ.

4.4. Шалгуулагчийн ур чадварын шалгалтын оноо ОУУБИС-ийн Багш, гадаад хэлний боловсрол (Солонгос хэл) хөтөлбөрийн хувьд хүчинтэй байна.

## **“АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ” ХӨТӨЛБӨРӨӨР ЭЛСЭГЧДИЙН УР ЧАДВАРЫН ШАЛГАЛТЫН УДИРДАМЖ**

### **НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1 Энэхүү удирдамж нь Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн А/143 дугаар тушаалаар батлагдсан “Оюутан элсүүлэх журам”, 2026 оны 2 дугаар сарын 06-ны өдрийн А/34 дугаар тушаалаар батлагдсан “Босго оноо тогтоох тухай” тушаал зэрэг эрх зүйн баримт бичгийг үндэслэн боловсруулагдсан болно.

1.2. “Аялал жуулчлал” хөтөлбөрөөр элсэгчдийн харилцааны ур чадвар, үйлчилгээний соёл, асуудал шийдвэрлэх чадвар, ерөнхий болон салбарын суурь мэдлэгийг үнэлэхэд энэхүү шалгалт чиглэнэ.

1.3. Ур чадварын шалгалтад 60 болон түүнээс дээш оноо (хэмжээст оноогоор 490) авсан тохиолдолд тэнцсэнд тооцно.

### **ХОЁР. ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

2.1. Ур чадварын шалгалтыг сургуулийн элсэлтийн комисс зохион байгуулна. 2.2. Шалгалтыг дараах хэлбэрээр зохион байгуулж болно.

- Танхимын
- Онлайн (шаардлагатай тохиолдолд)
- Холимог

2.3. Шалгалтыг ил тод, шударга, тэгш боломжийг ханган явуулна.

### **ГУРАВ. ШАЛГАЛТЫН ТӨРӨЛ, ХЭЛБЭР**

3.1. Ур чадварын шалгалтыг сонгох хариулт бүхий тестийн шалгалт хэлбэрээр авна. Энэ нь хоёр үндсэн хэсэгтэй байна.

3.1.1. Нөхцөлт даалгавар (Situational task)

- Асуудал шийдвэрлэх чадвар
- Ёс зүй, үйлчилгээ, харилцаа, хандлага

3.1.2. Ерөнхий мэдлэгийн шалгалт

- Монгол орны түүх, аялал жуулчлалын нөөц, онцлог
- Аялал жуулчлалын суурь ойлголт

### **ДӨРӨВ. ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ**

4.1. Ур чадварын шалгалтыг 100 оноогоор үнэлнэ.

4.2. Онооны бүтэц:

- Нөхцөлт даалгавар 50 оноо
- Ерөнхий мэдлэгийн шалгалт 50 оноо

4.3. Үнэлгээний шалгуур:

- 90–100 оноо – Маш сайн
- 80–89 оноо – Сайн
- 70–79 оноо – Дунд
- 60–69 оноо – Хангалттай
- 60-аас доош – Хангалтгүй

4.4. 60 ба түүнээс дээш оноо авсан элсэгчийг шалгалтад тэнцсэнд тооцно.

### **ТАВ. БУСАД ЗҮЙЛ**

5.1. Шалгалтын явцад хуулбарлах, шударга бус үйлдэл гаргасан тохиолдолд шалгалтыг хүчингүйд тооцно.

5.2. Шалгалтын дүнг ил тод зарлана.

5.3. Энэхүү удирдамжид тусгагдаагүй асуудлыг элсэлтийн комисс шийдвэрлэнэ.

## МАЛ ЗҮЙН ХӨТӨЛБӨРӨӨР ЭЛСЭГЧДЭЭС УР ЧАДВАРЫН ШАЛГАЛТ АВАХ УДИРДАМЖ

БШУ-ны сайдын 2024 оны 3 сарын 20-ны өдрийн А/143 дугаар тушаалаар батлагдсан “Оюутан элсүүлэх журам”, БШУ-ны сайдын 2026 оны 2 сарын 06-ны өдрийн “Босго оноо тогтоох тухай” А/34 дугаар тушаал, мал зүйн хөтөлбөрөөр элсэгчдийн ур чадварын шалгалтын удирдамжийн дагуу оюутан элсүүлнэ. Ур чадварын шалгалтад 60 (хэмжээст оноогоор 490) болон түүнээс дээш авсан тохиолдолд тухайн ур чадварын шалгалтад тэнцсэн гэж үзнэ.

Энэхүү журмын 2.4.5-д заасан бүртгүүлэгчийн ажлын газрын тодорхойлолт, нийгмийн даатгал төлсөн лавлагаа, өргөдөл болон ярилцлага / суралцах бэлтгэл хангасан байдал, авьяас чадвар, туршлага хувийн зан чанар, хэрхэн суралцахаа илэрхийлэх гэх мэт агуулгыг тусгасан байна/ зэрийг үндэслэн элсүүлнэ.

**Зорилго:** Элсэгчийн мал аж ахуйн чиглэлээр суралцах сонирхол, хандлага, суурь мэдлэг, харилцааны ур чадварыг үнэлэхэд оршино.

### Нэг. Шалгалтын хэлбэр

- Ярилцлага (аман хэлбэр)
- Хугацаа: 10-15 минут
- 3-5 багшийн бүрэлдэхүүнтэй комисс үнэлнэ.

### Хоёр. Үнэлгээний шалгуур ( нийт 100 оноо)

- Сонирхол, хандлага -20 оноо
- Суурь мэдлэг -20 оноо
- Сэтгэн бодох чадвар -20 оноо
- Харилцаа, илэрхийлэл -20 оноо
- Ёс зүй -20 оноо

### Гурав. Ур чадварын шалгалтын дүнгийн хуудас

#### Шалгуулагчийн мэдээлэл

Овог:.....

Нэр:.....

Регистрийн дугаар:.....

ЭШ-ын бүртгэлийн дугаар:.....

Шалгалт өгсөн газар, хаяг:.....

Шалгалт өгсөн хөтөлбөрийн/мэргэжил/ нэр:.....

	Үнэлгээний шалгуур	Анхны оноо	Авах оноо
1	Сонирхол, хандлага		20
2	Суурь мэдлэг		20
3	Сэтгэн бодох чадвар		20

4	Харилцаа, илэрхийлэл		20
5	Ёс зүй		20
	Нийт		100

Энэхүү журмын 2.15 д заасан ур чадварын шалгалтын гүйцэтгэлийн хувь буюу анхны онооноос хэмжээст оноо (хэмжээст оноо нь 200-аас 800-гийн хооронд байна)-г хөтөлбөр бүрээр БШУны сайдын 2024 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн А/143 дугаар тушаалын 1-р хавсралт "Оюутан элсүүлэх журам"-ын 3.2.9 -д заасан аргачлалаар тооцно. Анхны оноог А, хэмжээст оноог х гэж тэмдэглээд дараах байдлаар оноо (Х)-г тооцоолно Үүнд: Хэрэв шалгуулагчийн анхны оноо 0-ээс 59-ийн хооронд бол  $X=200+A*4.66$  Хэрэв шалгуулагчийн анхны оноо 60-аас 100-ын хооронд бол  $X=480+(A-60)*8$  Гэсэн томъёогоор олно.

Анхны онооны интервалд харгалзах хэмжээст оноог хүснэгтээр харуулав.

	Анхны оноо	Хэмжээст оноо
1	0-59	200-479
2	60-64.9	480-519
3	65-69.9	520-559
4	70-74.9	560-599
5	75-79.9	600-639
6	80-89.9	640-679
7	85-89.9	680-719
8	90-94.9	720-759
9	95-100	760-800

**Дөрөв.** Ур чадварын шалгалтын комисс шалгалтыг тухайн өдөрт нь дүгнэж, оноог элсэлтийн системд оруулна. Ур чадварын шалгалтын комисс нь шалгалтын дүнтэй холбоотой асуудлаар зөвхөн элсэлтийн төв комисст тайлбар хийх үүрэгтэй